



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 689

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 21,425,600.00 (хорин нэгэн сая дөрвөн зуун хорин таван мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ, 14,997,341.97 (арван дөрвөн сая есөн зуун ерэн долоон мянга гурван зуун дөчин нэгэн төгрөг ерэн долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Батлан хамгаалахын яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга Ж.Тамир, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 12 дугаар сарын 27 өдрийн  
 689 дугаар тогтоолын хавсралт



**ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМАНД  
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ширээ хуралдааны ЗГХТ 7200х33000 /16 хэсэг	2015.12.10	ш	1	21,425,600.00	21,425,600.00	14,997,341.97	6,428,258.03
	<b>Нийт дүн</b>			<b>1</b>		<b>21,425,600.00</b>	<b>14,997,341.97</b>	<b>6,428,258.03</b>
						(хорин нэгэн сая дөрвөн зуун хорин таван мянга зургаан зуу)	(арван дөрвөн сая есэн зуун ерэн дслоон мянга гурван зуун хечин нэгэн төгрөг ерэн дслоон мөнгө)	(зургаан сая дөрвөн зуун хорин найман мянга хоёр зуун тавин найман төгрөг гурван мөнгө)